



САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН **2013**



АГУУЛГА

1. Даргын Мэндчилгээ	03
2. Эдийн Засгийн Тойм	04
3. ИАЙТИ буюу Ард Санхүүгийн Нэгдэл	05
3.1. Танилцуулга	06
3.2. Бүтэц Зохион Байгуулалт	07
3.3. Санхүү	09
3.4. Үйл Ажиллагаа	10
3.5. Үнэлгээ	11
3.6. Хувьцааны Арилжаа	11
4. Хараат, Охин Болон Хөрөнгө Оруулалттай Компани	13
4.1. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл	13
4.2. Техник Технологийн Дээд Сургууль	15
4.3. Ард Кредит	17
4.4. Ард Даатгал	19
4.5. Монет Капитал	22
4.6. Тэнгэр Системс	23
5. Санхүүгийн тайлан	24

| ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч, түнш, харилцагч таны энэ гэгээтэй сайхан өдрийн амар амгаланг эрье!

2014 оныг бид гялалзсан сайхан мэдээтэй утглаа. Бидний хамтдаа үүсгэн байгуулж, амжилтанд хүргэхийн төлөө хамтдаа зүтгэсэн Equity Investment Trust (ИАЙТи) маань өнгөрсөн онд өр, зээлээ бүрэн төлж дуусган үйл ажиллагаагаа эмхэтгэсний зэрэгцээ стратегийн хувь нийлүүлэгчдийг эгнээндээ шинээр элсүүлэн, "Ард Санхүүгийн Нэгдэл" (Ард Холдингс) нэрийн дор нэгдэн ажиллах шийдвэрийг гаргасан түүхэн жил байлаа. Энэ бол бидний хамтын ажиллагаа, цуцашгүй хөдөлмөрийн үр дүн гэдгийг энд цохон тэмдэглэхийг хүчс байна.

2013 оны хувьд улс орны эдийн засгийн болон бизнес, хөрөнгө оруулалтын орчин хүндхэн байсантай холбоотойгоор зарим нэг хөрөнгө оруулалтаа хумих, үйл ажиллагааны хувьд илүү цомхон бөгөөд эрчтэй баг, бүтэц бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллалаа. Энэхүү Жилийн Тайланд бид үйл ажиллагаа хийгээд санхүүгийн тайлан, нэгдэл компанийн өнөөгийн бүтцийн зохион байгуулалт, өнгөрсөн хугацаанд гаргасан томоохон шийдвэр, тулгарсан асуудал, олсон шийдэл, цаашид баримтлах бодлогын талаар товч дурьдан танд хүргүүлж байна.

Бид анх "BlueOrchard", "Ropos" болон бусад компанийн хөрөнгө оруулалтыг "ЕСМ" (ИСиЭм) компаниар дамжуулан "Тэнгэр Санхүүгийн Нэгдэл" ХХК (ТэнГэр)-д оруулан ажиллаж байсан билээ. Өнгөрсөн онд ИСиЭм компанийг татан буулгах шийдвэрийг гаргаж, эхний ээлжинд "МАК" болон "Ropos"-ийн өмчийн 20 хувийг тусгаарлан шууд ТэнГэрт хувь эзэмшигүүлсэн билээ. Түүнчлэн, "MCS Holding" (МСиЭс), "Mongolia Opportunity Fund" (МОФ) болон Ард Холдингс зэрэг компани мөн адил ТэнГэрийн шууд хувьцаа эзэмшигч болох ажиллагаа одоо явагдаж байна. Ингэснээр бид ТэнГэрийн засаглалд шууд оролцон өөрсдийн эрх ашгийг бүрэн төлөөлөх боломж бүрдэх юм.

Б. Ганбат захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулж буй Техник Технологийн Дээд Сургууль (ТТДС)-ийн хувьд 2012 онд дээд сургууль, 2013 онд Технологийн ахлах сургуулийн зөвшөөрлийг тус тус нэмж аван үйл ажиллагаагаа өргөтгэн ажиллаж байна. Уг технологийн ахлах сургуулийн зөвшөөрлийн үндсэн дээр "Коосен" загварын сургуулийг байгуулах төслийг япон багш мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Монет Капитал ХХК (Монет Капитал)-ын хувьд өмнөх удирдлагын алдаатай бодлогоос үүдэн гарсан алдагдлыг зогсоон үйл ажиллагаагаа тогтвортжуулсан бөгөөд шинээр буй болсон санхүүгийн нэгдлийн бүрэлдэхүүнд нэгдэн Ард Холдингсийн өмнөө дэвшүүлээд байгаа зорилтод хүрэхэд өөрийн жинтэй хувь нэмрийг оруулан ажиллаж байна.

2007 онд үүсгэн байгуулсан тэтгэврийн сангийн үйл ажиллагааг бид тодорхой шалтгааны улмаас зогсоосон билээ. Гагцхүү "Монголын Тэтгэврийн Нэгдсэн Данс" ХХК (МТНД) компанийн эхлүүлсэн ажлыг үргэлжлүүлэн хийх шийдлийг олж, өнөөгийн хууль эрх зүйн орчинд зохицуулж үргэлжлүүлэн явуулах болсныг дуулгахад таатай байна. Хувь нийлүүлэгч Та бүхэн өөрийн компанийн энэхүү санаачлагыг дэмжин ажиллана гэдэгт итгэлтэй байна.


Мөн ТУЗ-ийн бүтцэд зарим өөрчлөлт оруулж, Ард Холдингсийг хөгжлийн шинэ шатанд хөтөлөн гаргах Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж эхлээд байна.

Бидний зорьсон хэрэг бүтэж, төлөвлөсөн ажил амжилттай хэрэгжинж, Компани болон хувь нийлүүлэгчдийнхээ нэр хүндийг өсгөн Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулахад Та бидний хамтын ажиллагаа, ажлын харилцан шүтэлцээ туйлын ач холбогдолтой билээ.

Хүндэтгэсэн,

Чулууны Ганхуяг
ТУЗ-ийн дарга

| ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ



2013 он Монгол Улсын эдийн засгийн хувьд дэлхийн эдийн засгийн таагүй нөлөөлөл, дотоодын хууль эрх зүйн тогтвортой байдал эзргэс шалтгаалан тааламжгүй нөхцөл байдал үргэлжилсэн жил байлаа. Гэсэн хэдий ч эдийн засгийн хамгийн чухал хэмнигдэхүүн болох ДНБ оны үнээр 17,550.2 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 6,144.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 25.2 хувиар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 11.7 хувиар тус тус өссөн байна.

Хэдийгээр ДНБ-ийн бодит өсөлт 2 оронтой тоонд байсан боловч төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь дотоодын дэд бүтэц сул хөгжсөн, улс төрөөс үүдэлтэй хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдал, зарим хууль тогтоомж, хөрөнгө оруулагчдыг үргээнээс үүдэлтэй юм.

Салбарлаар нь авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 13.5 хувь, аж үйлдвэр, барилгын салбарынх 20.1 хувь, үйлчилгээний салбарынх 10.0 хувиар нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөнд голлон нөлөөлсон бол уул уурхайн салбарын экспорт сул байлаа. Энэ нь дэлхийн эдийн засгийн төлөв сайжрахгүй хэвээр байсны зэрэгцээ Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширч, эрдэс түүхий эдийн эрэлт, үнэ зэрэгт сергэөр нөлөөлсөнтэй холбоотой юм.



Нэгөөтэйгүүр, хууль эрх зүй орчны тодорхойгүй байдлаас үүдэн гадаадын хөрөнгө оруулалт үндсэндээ зогсож, экспорт буран гадаад валютын ханш чангараахад хүргэсэн нь дотоодын эдийн засагт үлэмж сергэг нөлөөллийг авчирлаа. Уг сергэг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын бонд болон түүний баталгаатай бондыг гадаад зах зээлд арилжааны эх үүсвэр бүрдүүлж ажилласан ч гадаад валютын цэвэр албан нөөц 2013 оны эцэст өмнөх оныхоос 2,436.2 сая доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Банк санхүүгийн системийн хувьд тодотгох нэг зүйл нь системийн хэмжээгээр чанаргүй зээл 2013 онд 566.0 тэрбум төгрөгтэй болж өмнөх оныхоос 270.9 тэрбум төгрөгөөр буюу 91.8 хувиар өссөн явдал байлаа.

Гагцхүү 2013 оны сүүлээс дэлхийн томоохон улсуудын эдийн засаг эрчимтэй сэргэж, Монгол Улс хууль эрх зүйн орчноо бизнест ээлтэй болгох талаас дорвийт өөрчлөлтийг хийн дэд бүтэц тухайлбал, гацаад байсан төмөр замын хувьд ахиц гаргаж, уул уурхайн болон аж үйлдвэрийн томоохон төслийдийг хэрэгжүүлж эхлүүлэхээр шамдан ажиллаж байгаа нь 2014 онд эдийн засгийн нааштай хандлага үүсэх боломжийг бүрдүүлж байна.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ БУЮУ ХУУЧНААР EQUITY INVESTMENT TRUST

ИАйти ХХК буюу Equity Investment Trust LLC нь банк, банк бус санхүү, даатгал, үнэт цаас, ул хөдлөх хөрөнгө, боловсрол гэх мэт Монгол Улсын өндөр өсөлттэй салбаруудад хөрөнгө оруулалт хийн ажиллаж буй холдинг компани юм.

Анх 2005 онд ХасБанкны 10 жижиг хувьцаа эзэмшигч, 1.2 сая төгрөгийн дүрмийн сантай ИАйти компанийг үүсгэн байгуулж байсан бол 2013 оны жилийн эцсийн байдлаар тус Компани нь 370 орчим хувьцаа эзэмшигчтэй, 28 тэрбум төгрөгийн үнэлгээтэй болж өргөжөөд байна.



Оюун ухаан, хөдөлмөр, хөлс хүчээ зарцуулан бүтээсэн баялгийнхаа эзэн нь Монгол хүн өөрөө байх ёстой гэсэн энгийн бөгөөд тодорхой зарчмын үндсэн дээр энэхүү компани байгуулгадаж байлаа.

Эхний жилүүдэд зөвхөн Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн (тухайн үед ХАС-ГЭ Групп) хувьцааг ажилчдын хувьцаа эзэмшиүүлэх сангаас авч байсан бол аажмаар Монголын томоохон хөрөнгө оруулагч байгууллагуудын нэг болон өргөжин, бусад салбарт хийгдэж байгаа бүтээн байгуулалтад оролцох, шинэ хөрөнгө оруулагчдыг татан оруулах, хувьцаа эзэмшигчийнхээ хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгыг чиг болгон ажиллаж ирлээ. Аливаа ажлыг эхлүүлэх, амжилтанд хүргэхэд хэцүү байдаг. Бид ч өнгөрсөн хугацаанд алдаж, онон тэрнээсээ суралцахын зэрэгцээ бидэнд тохиосон боломж бүрийг ашиглахыг хичээн зах зээл дээр гарч буй зэрэг, сөрөг өөрчлөлт, бэрхшээлийг, даван туулиж ирлээ.

Ашигтай хөрөнгө оруулалтыг олж хийх, компанийг удирдах, санхүүжилт босгох, үнэ цэнийг нэмэгдүүлэх зэрэг амаргүй энэ ажлын ард гарахад хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, менежментийн багийн хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл онцгой үүрэг гүйцэтгэж ирснийг энд цохон дурьдах нь зүйтэй.

Энэхүү бидний бизнесийн амжилтын гол цөм болсон итгэлцлийг хадгалж, бэхжүүлэх үүднээс бид өнгөрсөн онд


компанийн тайлагнал, үйл ажиллагааны ил тод байдал, корпорацийн засаглалын хувьд зарчмын томоохон өөрчлөлтийг хийж туштай хэрэгжүүлж эхлэлээ.

Эхний үр дүн нь ч тодорхой харагдаж байна. Өмнөх жилүүдэд банк, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг Тэнгэр, мэргэжлийн боловсролын сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТТДС, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монет Капитал, тэтгэврийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг МТНД, үл хөрөнгийн түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Номын Хишиг" ХХК (Номын Хишиг), банк санхүүгийн байгууллагын програм хангамжийн хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Тэнгэр Системс" ХХК (Тэнгэр Системс) зэрэг компаниуудад хөрөнгө оруулалт хийж байсан билээ.

Харин 2013 онд ИАйти нь Ард Даатгал, Ард Кредит компаниудын хувьцааны тодорхой хэсгийг худалдан авч, өөрсдийн хөрөнгө оруулалтаа улам өргөжүүлэн даатгал, банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулах болсноор харилцан бие биеэ дэмжих, цогц санхүүгийн үйлчилгээ үзүүлэх компаниудын нэгдлийг бий болгож чадлаа. Энэхүү өөрчлөлтийн холбогдуулан ИАйти компани нь нэрээ Ард Санхүүгийн Нэгдэл буюу Ард Холдингс гэж өөрчлөн, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ

Хөрөнгө оруулалтын багцын удирдлагыг оновчтой болгох, олон улсын жишигт нийцсэн загварыг нэвтрүүлэх үүднээс хөрөнгө оруулалтын бүтцийг доор дурьдсан хэлбэрээр удирдан ажиллахаар төлөвлөөд байна.



Өөрөөр хэлбэл санхүүгийн бус салбар дахь компаниудыг шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу сан байгуулан төвлөрүүлж, активын удирдлагыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НЭР	ХУВЬЦААНЫ ТОО	ХУВЬ
1.	ИНТЕРГРУП ХХК	2,153,450	13.53%
2.	ЧУЛУУНЫ ГАНХУЯГ	2,128,610	13.37%
3.	ЮУБИАЙЖИ ХХК	1,468,449	9.23%
4.	АПОЛЛО ВИНТУРС ХХК	1,290,00	8.11%
5.	МАК ХХК	873,000	5.49%
6.	ЛУНА ЭНД ЛУНА ХХК	763,068	4.79%
7.	ЛХАГВАСҮРЭН СОРОНЗОН БОЛД	711,450	4.47%
8.	МӨНХ-ОЧИР СЭРГЭЛЭН	586,710	3.69%
9.	БАЯРТОГОХ НЭМЭХБААТАР	507,834	3.19%
10.	СЭДБАЗАР ГЭРЭЛТУЯА	450,000	2.83%
11.	ГАЛНЯМ УЯНГА	402,561	2.53%
12.	ДҮГЭРСҮРЭН БАТ-ОЧИР	313,650	1.97%
13.	МЯГМАСҮРЭН ЗОЛЖАРГАЛ	300,000	1.88%
14.	МАГВАН БОЛД	256,000	1.61%
15.	БАЯНЖАРГАЛ ДЭЛГЭРЖАРГАЛ	251,960	1.58%
16.	РОНОК ЛИМИТЕД	220,447	1.39%
17.	БАРАМСАЙ ГАНБАТ	201,296	1.26%
18.	ДОРЖГОТОВ ЭРДЭНЭЧИМЭГ	152,830	0.96%
19.	ЯДАМСҮРЭН НАЦАГДОРЖ	141,332	0.89%
20.	АРВАЙ АЛТЕРЬНАТИВ ХХК	117,670	0.74%
Эхний 20 хувьцаа эзэмшигч		13,290,317	83.505%
Бусад 349 хувьцаа эзэмшигч		2,625,310	16.495%
Нийт гаргасан хувьцаа		15,915,627	100.000%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Ч. ГАНХУЯГ (ТУЗ-ийн Дарга)



А. БАТБОЛД (ИАЙТИ ХХК)



Б. ГАНБАТ (ТТДС)



Г. ЦОГБАДРАХ (Хараат бус)



Л. СОРОНЗОНБОЛД (ХХБ)



С. ГЭРЭЛТҮЯА (Мон-Интэрнейшнл ХХК)



Б. НЭМЭХБААТАР (ЗАГ ХХК)



М. СЭРГЭЛЭН (ТиСиАЙ ХХК)



Н. ЦЭЛМҮҮН (МАК ХХК)



Ж. ОЮУНГЭРЭЛ (Л энд Л ХХК)



Л. ЖАВЗМАА (Аполло Вентурс ХХК)



П. БАТБАЯР (ИнтерГрупп)

| ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

- | Мэдээлэл технологи, барилга угсралт, тээвэр ложистик, эрүүл мэнд, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ИнтерГрупп нь манай компанийн хувьцаа эзэмшигч боллоо. Ингэснээр Ард Холдингийн хөрөнгө оруулалттай компаниудад синержи үүсгэн харилцан үр ашигтай ажиллах боломж нэмэгдэх юм.
- | МСиЭс-ийн эзэмшдэг хувьцаанаас хасч, ИСиЭм компанийн хувьцаанаас эзэмшүүлэв.
- | Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд харилцан ашигтай хамтарч ажиллах, санхүүгийн чадавхтай стратегийн хөрөнгө оруулагчтай байх зорилгоор хувьцааны арилжааг идэвхжүүлэн ажиллаж нийт хувьцаа зарах сонирхолтой хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Луна энд Луна ХХК, Заг ХХК гэх мэт компанийд худалдахад зуучлав.
- | 2013 онд нийт 2.2 тэрбум төгрөгийн дун бүхий хувьцааны арилжаа хийгдсэн байна.

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | Ж. Оюунгэрэл, Л. Жавзмаа, С. Гэрэлтуяа, П. Батбаяр нар ТУЗ-ийн гишүүнээр сонгогдож ажиллахаар болов.
- | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг жигдруулж, компанийн засаглалын асуудалд онцгой анхаарч, ТУЗ-ийн хороодыг байгуулахаар тогтов. Аудитын, хөрөнгө оруулалтын, эрсдэл санхүүгийн, засаглалын болон нэр дэвшүүлэх зэрэг хороодыг ТУЗ-ийн дэргэд байгуулж, бүтэц бүрэлдэхүүнийг тогтов.
- 1. Хөрөнгө оруулалтын хороо:** М. Сэргэлэн, Т. Тэлмэн, Ж. Оюунгэрэл, Л. Соронзонболд, П. Батбаяр
- 2. Засаглалын болон нэр дэвшүүлэх хороо:** Ж. Оюунгэрэл, Б. Нэмэхбаатар, С. Гэрэлтуяа, Б. Ганбат, П. Батбаяр
- 3. Эрсдэл санхүүгийн хороо:** Б. Ганбат, Л. Соронзонболд, П. Батбаяр, Г. Цогбадрах
- 4. Аудитын хороо:** Л. Жавзмаа, Г. Цогбадрах, М. Сэргэлэн, Т. Тэлмэн, С. Гэрэлтуяа


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- | Даатгал, банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг Ард Даатгал, Ард Кредит компанийг багтаасан Ард Холдингийг өөртөө нэгтгэж 2013 оны санхүүгийн салбарын хамгийн том хэлцлийг амжилттай гүйцэтгэв. Хэлцлийн дунд ИАЙТИ нь санхүүгийн салбарт цогц үйл ажиллагаа явуулах боломжтой болсон бөгөөд нэрээ өөрчлөн Ард Санхүүгийн Нэгдэл болгохоор шийдвэрлэлээ.
- | Монголын анхны хувийн тэтгэврийн үйлчилгээг нэвтрүүлсэн МТНД-ийн хөрөнгө оруулалтыг МОФ-д худалдан, тэтгэврийн дансдаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг тэтгэврийн данс эзэмшигчдэд эргүүлэн өглөө.
- | Тэтгэврийн дансны үйл ажиллагааг "Ард Актив" ХХХ (Ард Актив)-гоор дамжуулан явуулахаар тогтох, Ард Холдингс хоршооны гишүүнээр элсэв.
- | Хөрөнгө оруулалтын бодлогыг өөрчилж, төрөлжилт, эрсдлийн зохицой удирдлагыг нэвтрүүлэх зорилгоор Актив Зууч ХХК, iConcept ХХК (АйКонцепт)-д эзэмшиж байсан хувьцааг худалдан төлбөрийг хүлээн авлаа.
- | МОФ-д ИСиЭМ-ийн 27.57 хувь буюу ТэнГэрийн 2.77 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг амжилттай арилжив.
- | ИСиЭмийг татан буулгах, хөрөнгийг хуваарилах тал дээр бусад хувьцаа эзэмшигчдэй тохиролцоонд хүрлээ.
- | Компанийн мэдээлэл технологи, маркетинг сурталчилгаа талыг хариуцан ажиллах компаниар Wild Digital Agency (Уайлд)-ийг сонгон цаашид хамтран ажиллахаар шийдвэр гаргалаа.
- | Номын Хишиг компаниар дамжуулан эзэмшдэг үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийн хувияа бататгав.
- | Тэнгэр Системсийн үйл ажиллагааг сэргээж, "RightBanker" банкны удирдлагын системийг хөдөөгийн хадгаламж зээлийн хороодод үргэлжлүүлэн найдвартай хургэж, ашиглуулах, дараагийн хувилбарыг гаргах, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хороодод сурталчлах, борлуулах ажлыг эхлүүллээ.

| САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Нийт Хөрөнгө

(сая төгрөг)




Эздийн Өмч

(сая төгрөг)




Нийт Орлого

(сая төгрөг)



Ашиг

(сая төгрөг)



Нийт хөрөнгө 2013 онд 1.3 хувиар буурч, 9,432 сая төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн 73.2 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байна. Нийт хөрөнгийн бууралтанд өнгөрсөн онд ИСиЭМ-ээр дамжин ТэнГэрт эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтаас тодорхой хувийг МСиЭс, МТНД-д шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Компани нь 1,617 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 275 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт орлогын 95 хувийг хөрөнгө оруулалтын орлого бурдүүлж байна. Тус онд үндсэн үйл ажиллагааны зардал 387 сая, зээлийн хүүгийн зардал 257 сая, валютын ханшны өөрчлөлтөөс үүссэн алдагдал 206 сая төгрөг байлаа.

Нийт эзэмшигчдийн өмчийн дүн 2013 оны эцсийн байдлаар 5,080 сая төгрөгт хүрч өмнөх оноос 5.7 хувиар өсчээ. Уг өсөлтөнд 2013 онд нэгтгэсэн дүнгээр 689 сая төгрөгийн ашигтай ажиллаж хуримтлагдсан ашгийн хэмжээ өссөн нь голлон нөлөөлсөн байна.

| ҮНЭЛГЭЭ

(мянган төгрөг)

Хөрөнгө Оруулалт	Үнэлгээний Үндэслэл	Дотоод Үнэлгээ
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл 2013 Q4 BV	Арилжааны үнээр (BVx1.88)	11,598,601
ТТДС	Үл хөдлөх хөрөнгөөр	8,488,800
Ард Даатгал	Хөрөнгө оруулалтаар	3,960,000
Ард Кредит ББСБ	Хөрөнгө оруулалтаар	700,000
Ард Актив ХЗХ	Хөрөнгө оруулалтаар	13,000
Вайлд Дижитал	Хөрөнгө оруулалтаар	20,000
Монет Капитал	Хөрөнгө оруулалтаар	500,000
Номын Хишиг	Үл хөдлөх хөрөнгөөр	1,290,200
Үл хөдлөх хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгөөр	511,200
Мөнгөн хөрөнгө *		1,154,031
Дүн		28,235,832
Цэвэр авлага*		792,230
Цэвэр үнэлгээ		29,028,062
Эргэлтэнд байгаа хувьцааны тоо		15,384
Нэгж хувьцааны үнэлгээ		1.88


* 2014 оны 2 сарын 28-ны байдлаар

| ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

2013 онд хувьцаа эзэмшигчдийн хооронд нийт 2.2 тэрбум төгрөгийн дүн бүхий 9 удаагийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.


ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

(арилжааны үнээр)



| ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

(хуваалт хийгээгүй үеийн үнэд шилжүүлэн тооцсон)



Хувьцаа эзэмшигчид анх 2001 онд ИАЙТИ-ийн хувьцааг хөнгөлөлттэй үнэр буюу 100 төгрөгөөр худалдан авч эхэлж байсан бол хувьцааны хуваалт хийгээгүй үнийн дунд шилжүүлэн тооцвол ханш 2013 онд 10,018 төгрөг болж 100.2 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл хувьцааны өгөөж 9,918 хувь буюу жилийн дундаж өгөөж 763 хувь байна.

Жилийн дундаж өгөөж

763%

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ КОМПАНИ



ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Тэнгэрийн эрхэм зорилго нь гишүүн байгууллагуудын нэгдмэл хүч чармайлтыг бий болгосноор хувь нийлүүлэгчиддээ олгох нийгмийн болон санхүүгийн үр шимийг дээд хэмжээнд нь хүргэхд оршино. Харилцагчиддаа дээд зэргийн чанартай үйлчилгээ, үнэ цэнийг хүртээл болгон шинийг санаачлан эрч хүчтэй байдлыг эн тэргүүнд эрхэмлэнэ.

КОМПАНИЙН ТУХАЙ

2001 онд анх Хөгжлийн Алтан Сан ба Говийн Эхлэл банк бус санхүүгийн байгууллагууд нэгдэж, Х.А.С.-ГЭ групп буюу одоогийн Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг байгуулж байсан. Тус компани хэрэглэгчдийнхээ санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор банк, даатгал, лизинг, хөрөнгө оруулалт, моргейжийн болон арилжааны зээл олгох үйлчилгээг өөрийн нэгдэлд багтах ХасБанк, ХасЛизинг, Тэнгэр Даатгал, Тэнгэр Капитал, ТянРон, ХасСекьюрити компаниудаар дамжуулан хүргэдэг. Тэнгэрийн түүчээ болсон охин компани ХасБанк нь ил тод байдал, нийгмийн хариуцлагаар Монгол Улсад тэргүүлэгч арилжааны банк юм.

АЛСЫН ХАРАА

Тэнгэр нь санхүүгийн иж бүрэн үйлчилгээг тэгш байдлаар хүргэх зорилготой компаниудын нэгдэл юм. Тус нэгдэл нь тулганы гурван эрхэм зорилго болох Компанийн засаглал, Нийгмийн хариуцлага болон Байгаль орчныхоо өмнө хүлээх хариуцлагыг сайнкуулахдаа чанарын хам хэмжээг дээдэлж, эрч хүч бүхий манлайлагч байгууллага байхыг эрмэлзэхийн зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг өсгөнө.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

01. ХасБанкны урт хугацааны өсөлтийг хангах, тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Триодос Хөрөнгө Оруулалтын Сан, Симбиотикс Хөрөнгө Оруулалтын Сан болон Австрийн Хөгжлийн Банк (OeEB)-тай зээлийн гэрээ байгууллаа;
02. ХасБанк, Симбиотикс Хөрөнгө Оруулалтын Сантай хамтран 9.8 сая долларын бондыг амжилттай гаргав;
03. Олон улсын банк санхүүгийн салбарт нэр хундтэй "The Banker" сэтгүүлээс жил бүр зохион байгуулдаг оны шилдэг банкийг шалгаруулан шагнал гардуулах ёслолын ажиллагаа авсан дөрөв дэх удаагаа Лондон хотноо зохион байгуулагдаж, 2013 оны "Монгол Улсын шилдэг банк"-аар ХасБанкийг тодрууллаа;
04. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй шилдэг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдөг 17 дахь удаагийн "ENTREPRENEUR" ёслолын ажиллагаа 2013 оны 12 дугаар сарын 28-ны үдэш болж, ХасБанк Банкны салбарын 2013 Оны онцлох Энтрепренерээр шалгаран "Хүрэл Меркури" цомын эзэн болов;
05. Дэлхийн Банкны гишүүн байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон ХасБанк төлбөр тооцооны асуудал дээр хамтран ажиллах мастер гэрээнд гарын үсэг зурав;
06. Тэнгэр Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Тэнгэрийн 100 хувийн эзэмшлийн охин компани боллоо. Энэхүү үйл явдал нь компанийн бизнесийн байр суурийг бэхжүүлэх мөн даатгуулагч, иргэд, харилцагч байгууллагад банк санхүү, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цогц байдлаар хүргэхд чухал тулхэц болох юм.







САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Тус компанийн нийт хөрөнгө тайлант онд 1,892 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 68 хувиар, эзэмшигчдийн өмч 13 хувиар өсч, 145 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хөрөнгийн ихэнх хувь буюу 57 хувийг бүрдүүлж байгаа цэвэр зээл болон лизингийн багц 64 хувиар өссөн нь нийт хөрөнгийг өсөхөд нөлөөлсөн байна.


Нийт хөрөнгө




Эздийн өмч



Үйл ажиллагааны орлого



Ашиг



2013 онд үйл ажиллагааны нийт орлого 101 тэрбум болж өмнөх оноос 46 хувиар өссөн бол, цэвэр ашиг 26 тэрбум төгрөгт хүрч 62 хувиар тус тус өссөн байна. Энхүү өсөлтөнд нийт орлогын 77 хувийг бүрдүүлдэг хүүгийн орлого 26 хувиар, 11 хувийг бүрдүүлдэг хураамж, шимтгэлийн орлого 3 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.



ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон улсын жишиг хандлагад нийцсэн бие даан өрсөлдөх, хөрвөх чадавхи бүхий мэргэжлийн болон дээд боловсролтой ажилтан бэлтгэхэд оршино.

СУРГУУЛИЙН ТУХАЙ

Тус сургууль нь анх 1984 онд Барилгын техник мэргэжлийн 5 дугаар дунд сургууль нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1995 онд Монгол-Туркийн хамтарсан барилга техникийн коллеж, 2000 онд барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлдэх зорилгоор Техник Технологийн Коллеж болон өргөжсөн. 2012 онд БСШУ-наас тус коллеж нь дээд сургуулийн зөвшөөрөл авснаар шаталсан сургалтаар анхан, дунд, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж буй цор ганц хувийн хөрөнгө оруулалттай сургууль болжээ. Түүний зэрэгцээ Ази Номхон далайн бус нутгийн магадлан итгэмжлэлийн комиссоос тус сургууль нь магадлан итгэмжлэгдсэн байна. ТТДС нь байгуулагдсан цагаас хойш 30 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын мэргэжлийн боловсролын салбарт тэргүүлэх сургуулиудын нэг бөгөөд энэ хугацаанд нийтдээ 12 гаруй мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэсэн байна. Одоогоор тус сургууль нь 2,600 гаруй суралцагсад, 160 гаруй багш ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

01. ТУЗ-ийн шийдвэрээр бүтцэд зарим өөрчлөлт оруулж 3 алба, мэргэжлийн 9 тэнхимийг шинээр байгуулав;
02. Монголын Мянганы Сорилтын Сангийн төслийн хүрээнд “Монгол Улсын Барилгын Мэргэжлийн Жишиг Сургууль” болж батламжлагдсан. Энэхүү төслийн хүрээнд нийт 3.1 сая долларын 16 төсөл хэрэгжксэн болно;
03. 2013-2014 оны хичээлийн жилд ТТДС-ийн дэргэдэх Технологийн ахлах сургуулийн тусгай зөвшөөрлийг авч, Монгол Улсад “Коосэний тогтолцоог нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхлэв;
04. Засгийн Газрын мөрийн хөтөлбөр болон БХБЯ-ны бодлогод нийцүүлэн “Байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хэмнэлтэй барилгын үйлдвэрлэлийг дэмжих” төслийг Европын Холбоо, Бүгд Найрамдах Чех Улсын Олон улсын Каритас байгууллагын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлж эхлэв;
05. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хотын Ойн аж үйлдвэрийн коллеж, Австралийн Холмсглен Их Сургуультай судалгаа шинжилгээ, мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох хамтын ажиллагааг эхлүүлэв;
06. Тус сургуульд ХБНГУ, Австрали, Япон, БНСУ, Шинэ Зеланд зэрэг орнуудаас мэргэжлийн нийт 7 мэргэжилтэн, зочин профессор багш нар ажиллаж, туршлага солилцож байна;
07. БНСУ-ын Дун-И Технологийн дээд сургуультай “Автомашины механик” мэргэжлээр хамтран хэрэгжүүлж буй “Хос дипломын хөтөлбөр”-ийн нээлтийг хийв;
08. ТТДС-ийн нэрэмжит MCYT, Коллежийн Мужаан, Гагнуурын мэргэжлийн багш суралцагсдын ажил мэргэжлийн “Ур чадвар-2013” уралдааныг зохион байгуулж хотын 7, орон нутгийн 23 сургуулийн 30 багш, 27 суралцагч оролцсон байна;
09. МУ-ын Хөдөлмөрийн яамнаас МБС-ын нэр хүнд болон стандартыг дээшлүүлж Монгол ур чадварыг дэлхийн түвшинд хүргэх зорилгоор зохион байгуулсан “Монгол ур чадвар-2013” улсын анхдугаар уралдаанд тус сургуулийн сурагчид өрөг угсралч, гагнуур гэсэн 2 төрлөөр оролцож тус бүр түрүүлж амжилт гаралаа;
10. 2013 онд богино хугацаанд мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ажил мэргэжилгүй 160 хүн сургаж мэргэжил эзэмшүүлсэн байна.






САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт хөрөнгө 2013 онд 4.7 хувиар өсч, 6,193.8 сая төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн 22.5 хувийг эргэлтийн хөрөнгө, 77.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө зээлж байна. 2013 онд тус ТТДС нь 2,982.6 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж, өнгөрсөн оноос 11.2 хувиар өссөн байна.


Нийт Хөрөнгө

(сая төгрөг)




Эздийн Өмч

(сая төгрөг)




Нийт орлого

(сая төгрөг)



Ашиг

(сая төгрөг)



Үндсэн уйл ажиллагааны зардал болон валютын ханшны огцом өөрчлөлтөөс үүссэн алдагдлаас улбаалан ашгийн түвшин буурч, 30.8 сая төгрөг болсон байна.

Нийт эздийн өмчийн дүн 2013 оны эцсийн байдлаар 2,086.0 сая төгрөгт хүрч өмнөх оноос 1.5 хувиар өсчээ.



АРД КРЕДИТ ББСБ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэгч зах зээлийн тэргүүлэгч байгууллага.

АЛСЫН ХАРАА

Монгол Улсад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх гол хүч болж, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч жишиг байгууллага байх.

КОМПАНИЙН ТУХАЙ

Ард Кредит Банк Бус Санхүүгийн Байгууллага нь 2011 оны 4 дүгээр сард ИнтерГруппын хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан үндэсний аж ахуйн нэгж юм. Ард Кредит нь үүсгэн байгуулагдсан цагасаа хойш зээлийн үйл ажиллагаа явуулах, валиутын арилжаа эрхлэх, хөрөнгө оруулалт болон санхүүгийн зөвлөгөө өгөх гэсэн Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд зээлийн үйлчилгээгээр голлон амжилттай ажиллаж ирсэн.

2013 оны 6 дугаар сард үйлчилгээнийхээ цар хүрээг тэлж, зах зээл дээр хурдацтай хөгжих, дэвшилтэт технологийг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх зорилгоор салбартай олон жилийн мэдлэг, туршлага хуримтлуулсан хөрөнгө оруулагчдыг татан оруулж ирсэн билээ. Ард Кредит нь өнгөрсөн хугацаанд компанийн удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж, стратегийн төлөвлөгөө, бодлого шинээр гарган зах зээл дээрх тэргүүний байр сууринд гарах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

2013 оны 12 дугаар сард компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон бөгөөд бид Ард Санхүүгийн Нэгдэлийн шууд хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгджэн үйл ажиллагаагаа явуулж байна.




Тус компани нь орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан бичил зээлийн үйлчилгээг хүн бүрт илүү ойрхон, хүртээмжтэй, уян хатан болгох зорилготойгоор ажиллаж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

01. 2013 оны 7 дугаар сард хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, 600 сая төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалт татсанаар дүрмийн сангaa 1.1 тэрбум төгрөгт хүргэсэн;
03. Төлөөлөн Удирдах Зөвлөлийг шинээр байгуулж бичил санхүүгийн чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан удирдлагын баг бүрдүүлэн, компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэв;
04. Шинэ оффисын байранд нүүн орж бүрэн тохижилт хийсэн;
05. Компанийн шинэ вебсайтыг ашиглалтанд оруулж, сошиал медиа маркетингийн компанийт ажлыг эхлүүлсэн;
06. Үйлчилгээнийхээ цар хүрээг өргөжүүлэх үүднээс 550 сая төгрөгийн өрийн бичиг гаргах зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч, хаалттай хүрээнд арилжаалах ажлыг эхлүүлж 2014 оны эхний улиралд амжилттай санхүүжилт босголоо.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2013 онд Нийт хөрөнгө 226 хувь өсч 1,827 сая төгрөгт хүрсэн бол Зээлийн багц (цэвэр) 197 хувь өсч 1,658 сая төгрөгт хүрчээ. Нийт эздийн өмчийн дүн 1,279.2 сая төгрөгт хүрч өмнөх оноос 130 хувь өссөн бөгөөд энэ нь шинэ хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй шуд холбоотой юм.



2013 онд 261 сая төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан бөгөөд өнгөрсөн 2012 онтой харьцуулахад 160 хувь өссөн дүн юм. Цэвэр ашиг 123.3 сая төгрөг болж, өмнөх оноос 278 хувиар өссөн байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

01. Бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд (БЖБЭ) ихэнх тохиолдолд банк ба санхүүгийн байгууллагад хандаж зээл, санхүүжилт авахад барьцаа хөрөнгийн болон бусад шалтгаанаас болоод бэрхшээлтэй байдаг билээ. Тийм учраас БЖБЭ бизнесээ цааш нь өргөжүүлэн томруулж улмаар өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд хүндрэлтэй байдаг. Бид зээлийн үйлчилгээгээ аль болох БЖБЭ-д хүртээмжтэй мөн чирэгдэл багатай байдлаар хүргэхийг зорин ажиллахаас гадна тэдэнд санхүүгийн зөвлөгөө өгч, мэдлэг мэдээллээр ханган ажиллах нь бидний эрхэм зорилго юм.
02. Ард Кредит нь 2013 оноос Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой (ХБСХДХ) хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү холбоо нь Монгол Улсын нутгаар тархан байршсан 50 хадгаламж зээлийн хоршоог өөртөө нэгтгэсэн байгууллага юм. Эдгээр хоршоодод нэмэлт санхүүжилт болон сургалт, зөвлөгөө өгөх үүднээс энэхүү хамтын ажиллагааг эхлүүлэн Бөөний зээл хэмээх бүтээгдэхүүн гарган ажиллаж байна.
03. Мөн бид нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллагын хувьд спортын баг, тамирчдыг бүх талаар дэмжин ажилладаг. 2013 оны хувьд бид хүндийг өргөлтийн паралимпийн тамирчин Содномпилжээг Малайз улсад болсон 2013 оны Азийн аваргын тэмцээнд явах зардлыг гаргаж, 23-р сургуулийн хөл бөмбөгийн багийн Дуулиан-2020 тэмцээнд оролцох санхүүгийн асуудлыг шийдэж өгсөн бөгөөд хувцас хэрэглэлээр бүрэн хангаж ажиллалаа.



АРД ДААТГАЛ ХХК

ЭРХЭМ ЗОРИЛГО

Даатгуулагчийн хэрэгцээнд тохироулсан, ёс зүйг баримтласан, даатгалын шилдэг үйлчилгээг үзүүлэх.



АЛСЫН ХАРАА

Ард Даатгал ХХК нь 1994 онд байгуулагдан, 20 жилийн турш үндэсний хэмжээнд даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж буй, анхны хувийн даатгалын компани юм. 2004 онд хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Их Британийн Виттингтон групп тус компанийд хөрөнгө оруулалт хийж, хувь нийлүүлэгч болсноор Ард Даатгал компани нь гадаадын хөрөнгө оруулалттай анхны даатгалын компани болж, олон улсын болон Европын даатгалын зах зээлийн шилдэг туршлагыг Монгол Улсын даатгалын зах зээлд нэвтрүүлж ажиллаж байна.


2011 онд тус компани нь Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэснээр даатгалын салбартаа нийт хөрөнгө, нөөц сан, хураамжийн орлого зэрэг үзүүлэлтүүдээр тэргүүлэгч даатгалын компанийдын нэг болсон юм.

Одоогийн тус компани нь улсын хэмжээнд 30 гаруй салбараар нийт 100 гаруй үндсэн ажилтан, даатгалын мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Нийт Хөрөнгө

(сая төгрөг)




Эздийн Өмч

(сая төгрөг)




Хураамжийн Орлого

(сая төгрөг)



Ашиг

(сая төгрөг)





2013 онд нийт хөрөнгө 7.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 96.0 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдэх 4.0 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна. Нийт өр төлбөр 3.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан бол ээдийн өмч 3.9 тэрбум төгрөгт хүрч 36.1 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь дүрмийн санг 750 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант үеийн ашиг өмнөх онтой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэнтэй холбоотой.

(мянган төгрөг)

Нийт хураамжийн орлого	Нэхөн төлбөр	Нийт харилцагчид
10,093,942.35	6,267,633.04	65,947.00
Цэвэр хураамжийн орлого	Нөөц сан	Дүрмийн сан
5,837,831.30	3,239,530.40	2,750,000.00
Нийт хөрөнгө	Ашиг	Төлбөрийн чадварын зохистой харьцаа (>100)
7,128,290.94	2,574,120.52	198.52

Орлогын хувьд нийт хураамжийн орлого өмнөх онтой харьцуулахад 18.5 хувиар өсч, 10.1 тэрбум төгрөгт хүрч, нийт ашиг 2.5 тэрбум төгрөг болсон байна. Ашиг өмнөх оноос 4 дахин өсөхөд компани үл хөдлөх хөрөнгө худалдсан нь нөлөөлсөн бөгөөд цэвэршүүлсэн ашиг нь 1.0 тэрбум төгрөг болж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- 2013 онд Ард Даатгал нь Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг ТОП-150 аж ахуйн нэгж шалгаруулалтын “ТОП-5” даатгалын компанийн тэргүүлэгчээр шалгарч, даатгалын салбартаа тэргүүлэгч гэдгээ ахин баталлаа;
- 2013 онд хувьцаа эзэмшигчдийн бүтэц өөрчлөгдөн тус компанийн хувьцаа эзэмшигчээр санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт хийдэг ИАЙТИ буюу Ард Холдингс орж ирлээ. Ингэснээр Ард Даатгал компани цаашид Ард Санхүүгийн Нэгдлийн охин компаниудтай харилцан дэмжлэг бүхий үйл ажиллагааг бий болгож, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, илүү үр ашигтай ажиллахаар зорьж эхлэв;
- Дэлхийн томоохон санхүүгийн зөвлөх үйлчилгээний байгууллагуудын нэг болох PwC (PricewaterhouseCoopers) компаниар засаглалын үнэлгээ хийлгэж, өгөгдсөн зөвлөмж, чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна;
- 2012 онд манай томоохон харилцагч байгууллагын даатгуулсан үл хөдлөх хөрөнгө (агуулах), агуулах дахь бараа материалд гол гарч үлээмж хэмжээний хохирол учирсан бөгөөд уг хохирлын нэхөн төлбөрийг давхар даатгалын Ханновер РЕ компаниас 100 хувь гаргуулан өгч, улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш их хэмжээний хохирлыг давхар даатгагчаас төлүүлсэн анхны тохиолдолд болсон байна. Энэ нь манай компани өөрсдийн авсан эрсдэлийг хэрхэн зөв хуваарилж дэлхийд нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудтай хамтран ажилладгийг харуулсны зэрэгцээ давхар даатгалын гэрээний үр өгөөжийг даатгуулагчдад харуулсан чухал үйл явдал боллоо.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

01. Бид хүрээлэн буй байгаль орчин хамгаалах ўйл ажиллагааг Компанийн нийгмийн хариуцлагын томоохон хэсэг гэж үздэг бөгөөд өнгөрсөн онд бид Дорноговь аймгийн нутагт байрлах Хамрын хийдэд 400 суулгааг нийт ажилчдын хамт очиж суулган Ард Даатгалын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг байгууллаа;
02. Байгаль орчин хамгаалах чиглэлээр ўйл ажиллагаа явуулдаг “Экологи – Сэлбэ Гүнжийн Рашиан” Нөхөрлөлтэй байнга хамтран ажилладаг бөгөөд энэ ажлын хүрээнд Сэлбэ Гүнжийн ойн орчныг сайжруулах, ойн хог хаягдлыг арилгах, шинээр мод, бут суулгах, ойжуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр ўйл ажиллагаанд тодорхой хэмжээний санхүүжилт гарган хамт олноороо идэвхтэй оролцдог боллоо;
03. Спорт соёлын арга хэмжээ болон залуусын эрүүл мэндийг дэмжих зорилгоор Монголын Сагсан Бөмбөгийн холбооноос зохион байгуулсан үндэсний PEPSI доод лигт “Ардын Бүргэдүүд” нэрээр 15 тоглогч 1 дасгалжуулагчтай баг тоглуулж, шаардлагатай санхүүжилтийг олгон дэмжин ажилласан;
04. 2013 онд зохион байгуулагдсан “Монголын Премиэр Лиг”-ийн хаврын болон намрын 2 улирал дарааллан “ФС Ард Даатгал” нэрээр 20 тоглогч, 1 мененжертэйгээр амжилттай оролцуулсан бөгөөд шаардлагатай санхүүжилтийг олгон дэмжиж ажиллав;
05. 164-р цэцэрлэгийн 30 хүүхдтэй нэг ангийг ширээ сандал зэргийг бэлдэж тохишуулан, хаягжуулж Ард Даатгал компанийн нэрэмжит ангийг нээсэн;
06. Паралимпийн пауэрлифтингийн төрөлд 2013 оны 88 кг хүртэлх жинд амжилтаараа дэлхийд 11-д бичигдэж буй Монгол Улсын аварга тамирчин Энхбаярын Содномпилжээг пауэрлифтингийн 2013 оны Малайз Улсын Куала Лумпур хотод болох IPC Powerlifting Asian Open Championships Азиин аварга шалгаруулах тэмцээний зардлыг Ард Кредитын хамт бүрэн санхүүжүүлж оролцуулсан;
07. Ард Даатгал урлаг соёлын салбарыг үргэлж дэмжиж ажилласаар ирсэн бөгөөд энэ ажлын хүрээнд Зохиолч Б. Шүүдэрцэцгийн зохиолоор найруулагч Б. Болдуяг, Т. Алтантуяа нарын найруулсан дэлгэцийн урлагын бүтээл болох “Домогт Ану Хатан” уран сайхны киног, мөн “Драмын Мэргэжлийн Жүжигчдийн Төв”-өөс санаачлан Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Улсын Драмын Эрдмийн Театр, Хүүхдийн Төлөө Газар зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулдаг “Драмын урлагийн дээд шагнал гардуулах - Гэгээн муза” наадмыг тус тус 2013 онд ивээн тэтгэн ажилласан байна;
08. **СОС-ХҮҮХДИЙН ХОТХОНД:**

“Ард Даатгалын хамт олон – Хүүхдүүдтэй нэгэн өдөр” арга хэмжээнд Компанийн хамт олон тус Хотхоны хүүхдүүдийн дунд хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, нийт 250 хүүхдэд гарын бэлэг бэлэглэсэн;

Эрдмийн баяр арга хэмжээнд Компанийн хамт олон тус Хотхоны өмнөх хичээлийн жилдээ онцрайн суралцсан хүүхдүүдэд шинэ хичээлийн жилдээ хэрэглэх хичээлийн хэрэгсэл бэлэглэж, хүүхдүүдийн дунд эрүүл саруул, эрдмээр баян байж эх орондоо хүндтэй иргэн болохын утга учрыг илэрхийлсэн сонирхолтой ярилцлага хийсэн болно.



МОНЕТ КАПИТАЛ ХХК

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэргэнжлийн зөвлөгөө, мэдээллийн үндсэн дээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд санхүүгийн зуучлалын цогц үйлчилгээг чанартай хүргэн, хөрөнгийн зах зээлийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах.

КОМПАНИЙН ТУХАЙ

Монет Капитал нь 1997 онд анх байгуулагдсан бөгөөд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсын ууган компанийн нэг юм.

Тус компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон холбогдо тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагчиддаа үнэт цаас, хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.


Монет Капитал нь 12 мянган гаруй иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцох дансыг нээж, 10 аж ахуй нэгжид 74.3 тэрбум төгрөгийн санхүүжилт босгох болон нэгдэх нийлэх үйл ажиллагаанд зуучлагчаар оролцоод байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2013 онд компанийн нийт хөрөнгө 549.0 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүний 85.0 хувь нь эргэлтийн хөрөнгө, 25.0 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байлаа. Нийт өр төлбөр 304.8 сая төгрөг, эздийн өмч 244.3 сая төгрөг болж, тус бүр 43.6 болон 7.4 хувиар буурсан байна.


Нийт Хөрөнгө

(сая төгрөг)




Эздийн Өмч

(сая төгрөг)




Нийт Орлого

(сая төгрөг)



Ашиг

(сая төгрөг)



Орлогын хувьд үйл ажиллагааны орлого хоёр дахин өссөн бол үйл ажиллагааны зардал 26.5 хувь өссөн байна. Зардлын өсөлтөд 2012 онд олон улсын хувьцааны зах зээлээс хүлээсэн хувьцааны ханшийн алдагдал нөлөөлсөн байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

01. Компани удирдах багтаа өөрчлөлт оруулж, Гүйцэтгэх Захирлаар А. Батболдыг томиллоо;
02. Тайлант хугацаанд нийт харилцагчдын тоо 12,413-д хүрсэн байна;
03. 2013 онд дотоодын зах зээлд 307 сая төгрөгийн үнэт цаас арилжаалсан бөгөөд энэ нь нийт зах зээлийн 0.3 хувийг бүрдүүлсэн байна;
04. Олон улсын зах зээлд 346 сая төгрөгийн арилжаа хийхэд зуучлав;
05. Мөн тус онд хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерын чиглэлээр 14 дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжтэй хамтран ажилласнаас компанийн үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийх, зээлд зуучлах, хаалттай хүрээнд өрийн бичиг гаргахад андеррайтераар ажиллах гэх мэт 5 аж ахуйн нэгжийн ажлыг амжилттай хийж дуусгаад байна.

| ТЭНГЭР СИСТЕМС ХХК

Тэнгэр Системс нь банк санхүүгийн салбарт хэрэглэгдэж буй программ хангамж зохиох, хөгжүүлэх чиглэлээр байгуулагдсан бөгөөд одоогоор банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоодод санхүүгийн цогц шийдэл бүхий програм хангамжийг санал болгон ажиллаж байна.

Тус компани нь ХасБанктай франчайзингийн гэрээгээр ажилладаг Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд зориулан 2009 онд "Right Banker" программыг зохион бүтээсэн бөгөөд 2013 оны байдлаар 26 хоршоо уг программыг гэрээний дагуу үйл ажиллагаандaa ашиглаж байна. Одоогоор программыг сайжруулах, хөгжүүлэхээр тус компанийн шинэ багийнхан ажиллаж эхлээд байна.

| УАЙЛД ДИЖИТАЛ ХХК

Тус компани нь орчин үеийн хэрэгцээ шаардлагын дагуу мэдээллийн технологи дээр сууриссан маркетингийн цогц шийдэл бүхий үйлчилгээг үзүүлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд шинэлэг үйлчилгээг харилцагчиддаа санал болгон ажиллаж байна. Уайлд нь хэдийгээр байгуулагдаад удаагүй байгаа хэдий ч хэд хэдэн гэрээт ажлыг амжилттай гүйцэтгээд байна.

| АРД АКТИВ ХЗХ

Тус хоршоо нь МТНД-ийн үндэслэсэн хувийн тэтгэврийн хадгаламжийн тогтолцоог үргэлжлүүлэн ажиллахаар үүсгэн байгуулагдсан бөгөөд цаашид тэтгэврийн хуримтлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч ХЗХ болохоор зорин ажиллаж байна.

Нөгөө талаас Ард Санхүүгийн Нэгдэл болон хамтын ажиллагаа бүхий компаниудын ажилтан болон бусад гишүүдэд санхүүгийн түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллах санхүүгийн байгууллага болох юм.

| НОМЫН ХИШИГ ХХК

ИАЙТИ ХХК нь үл хөдлөх хөрөнгийн салбарт хөрөнгө оруулалт хийх зорилгоор 2011 онд Номын Хишиг ХХК-ийн 20 хувийн хувьцааг худалдан авсан билээ.

Одоо тус компани нь өөрийн эзэмшилийн барилгыг түрээслүүлэж орлого бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тус барилга нь байршилын хувьд хотын төвийн бизнесийн гол бүсэд оршдог ихээхэн давуу талтай юм.

| САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ИАЙТИ ХХК

(сая төгрөг)

	2012	2013
ХӨРӨНГӨ	9,562.65	9,432.3
Эргэлтийн хөрөнгө	1,421.86	2,084.4
Эргэлтийн бус хөрөнгө	8,140.79	7,347.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,562.65	9,432.4
Богино хугацаат өр төлбөр	2,604.99	4,275.30
Үрт хугацаат өр төлбөр	2,150.49	76.6
Нийт өр төлбөр	4,755.48	4,351.90
Эзэмшигчдийн өмч	4,807.18	5,080.4
Хуримтлагдсан ашиг	47.14	736.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	-	1,617.7
Цэвэр ашиг	-289.98	689.7

Тайлант хугацаанд гаргасан томоохон гүйлгээ:

1. МТНД ХХК-ийн хөрөнгө оруулалтыг худалдсан
2. МСиЭс ХХК-ийн эзэмшиж байсан хувьцааг буцаасан
3. Өр төлбөрийг барагдуулсан
4. Зарим нэг компаниудад эзэмшиж байсан хувьцааг худалдсан

| АРД ДААТГАЛ ХХК

(сая төгрөг)

	2012	2013
ХӨРӨНГӨ	6,345.00	7,128.29
Эргэлтийн хөрөнгө	4,953.00	6,840.62
Эргэлтийн бус хөрөнгө	1,391.99	287.67
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,345.00	7,128.29
Богино хугацаат өр төлбөр	127.45	26.5
Үрт хугацаат өр төлбөр	3,380.01	3,239.53
Нийт өр төлбөр	3,507.46	3,266.03
Нөөц сан	3,380.01	3,239.53
Эзэмшигчдийн өмч	2,837.53	3,862.26
Хуримтлагдсан ашиг	837.53	1,112.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	8,520.49	10,093.94
Цэвэр ашиг	592.78	2,574.12

Тайланы хугацаанд гаргасан томоохон гүйлгээ:

1. Ул хөдлөх хөрөнгөө худалдсан
2. Дүрмийн сан нэмэгдсэн

АРД КРЕДИТ ББСБ

(сая төгрөг)

ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЭЛ	2012	2013
Нийт хөрөнгө	560	1,827.10
Зээлийн багц (цэвэр)	556.6	1,658.10
Эзэмшигчдийн өмч	557.5	1,280.80
Нийт өр төлбөр	2.5	546.3

(сая төгрөг)

ОРЛОГО, ҮР ДҮН	2012	2013
Хүү болон түүнтэй адилтгах орлого	97.4	261.2
Хүү болон түүнтэй адилтгах зардал	-	17.7
Үйл ажиллагааны зардал	54.1	139.8
Татварын дараах цэвэр ашиг	37.1	123.3

Тайлант хугацаанд гаргасан томоохон гүйлгээ:

1. Хаалттай хурээнд бонд гаргасан
2. ИАҮТи ХХК-аас зээл авсан

| ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

(сая төгрөг)

	2012	2013
ХӨРӨНГӨ	5,915.98	6,193.83
Эргэлтийн хөрөнгө	1,331.31	1,722.86
Эргэлтийн бус хөрөнгө	4,584.67	4,470.97
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,918.98	6,193.83
Богино хугацаат өр төлбөр	3,198.94	3,446.33
Үрт хугацаат өр төлбөр	662.51	661.64
Нийт өр төлбөр	3,861.44	4,107.97
Эзэмшигчдийн өмч	2,057.54	2,085.86
Хуримтлагдсан ашиг	389.6	30.85
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	2,612.80	2,880.52
Цэвэр ашиг	298.7	30.85

Тайлант хугацаанд гаргасан томоохон гүйлгээ:

1. Мянганы Сорилын Сангаас 3.5 сая долларын хандив хүлээн авсан.

МОНЕТ КАПИТАЛ ХХК

(сая төгрөг)

	2012	2013
ХӨРӨНГӨ	804.27	549.03
Эргэлтийн хөрөнгө	389.51	466.41
Эргэлтийн бус хөрөнгө	414.77	82.62
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	804.27	549.03
Богино хугацаат өр төлбөр	540.34	304.76
Урт хугацаат өр төлбөр	-	-
Нийт өр төлбөр	540.34	304.76
Эзэмшигдийн өмч	263.93	244.27
Хуримтлагдсан ашиг	-433.61	-448.18
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	265.9	561.31
Цэвэр ашиг	-187.95	-14.58

Тайланы хугацаанд гаргасан томоохон гүйлгээ:

- ИАЙТИ ХХК-ийн зүгээс алдагдлын зарим хэсгийг хаасан

ОН ГАРААД ХИЙГДСЭН АЖИЛ:

01. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д эзэмшиж байсан хувьцаанаас 2.7 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг худалдаж, хувьцаа худалдсанаас олсон орлогоос арилжааны банкнаас урьд нь авсан зээлээ төлж дуусгав.
02. Ард Даатгал, Ард Кредитын Төлөөлөн Удирдах Зөвлөлийг шинэчлэн байгуулж, өөрсдийн төлөөлөгчийг оруулж, засаглалын хувьд тодорхой ахиц гаргав.
03. Компанийн ТУЗ-ийн хороод, бүтэц бүрэлдэхүүнийг эцэслэн батлав.
04. Хөрөнгө оруулсан хараат болон охин компаниудтай менежментийн гэрээ байгуулан ажиллах, менежментийн хөлс тохиролцож авч байхаар болов.
05. Нээлттэй хувьцаат компани болохтой холбоотойгоор компанийн маркетинг, брэндинг, сошиал медиа сурталчилгаа хийх багийг сонгон хөрөнгө оруулалт хийж, хамтарсан хөрөнгө оруулалттай Уайлд Дижитал Эйженси ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэв.
06. 2013 оны санхүүгийн тайланда аудит хийх компаниар БДО Аудит компанийг сонгов.

2014 ОНЫ ҮНДСЭН ЗОРИЛТ:

01. Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нэрээр нээлттэй хувьцаат компани болох бэлтгэлийг базааж эхний ээлжинд хөрөнгийн биржид хаалттай хувьцаат компани хэлбэрээр бүртгүүлэх;
02. Ард нэрээр брэндинг хийх, группын бусад компаниудын маркетингийн ажлыг уялдуулах;
03. Компанийн засаглалыг сайжруулах талаар цогц арга хэмжээ авах;
04. Компанийн эрсдлийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалтын удирдлагыг шат бүрт сайжруулах;
05. БДО Аудитын хийсэн тайлангийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;
06. Техник Технологийн Дээд Сургууль дээр бутцийн өөрчлөлт хийх, үл хөдлөх хөрөнгийн ёмчлөл, эзэмшлийн асуудлыг тусгаарлах;
07. Ард Даатгалын бүртгэл, даатгалын систем, удирдлагын мэдээллийн систем, засаглалыг сайжруулах;
08. Ард Кредит ББСБ-ийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж санхүүжилт босгох, итгэлцлийн үйлчилгээг эхлүүлэх;
09. Монет Капитал ХХК-ийн нэрийг солих, үйл ажиллагааг сайжруулан ашигтай түвшинд хургэх;
10. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, санхүүгийн бус хөрөнгө оруулалтыг сан руу шилжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт татах;
11. Тэтгэврийн үйлчилгээг өргөжүүлэх;
12. Хөдөөгийн ХЭХ-дод хүрч ажиллана.



САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

Монгол улс 14200, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Амарын гудамж, Сити Центр, 403 тоот
Ш/х: 26/389, И-мэйл: info@eit.mn
Утас/Факс: + 976 11 311495
Вэбсайт: www.ardholdings.com

design by